

**“Иргэд төсвөө хянана”
иргэний нийгмийн
сүлжээ**



**“2016 ОНЫ НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙГ
ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН
БА БАРИМТ БИЧГИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ”**

Мониторингийн тайлан

2016 он

Төсөл хэрэгжүүлэгч:

**“Иргэд төсвөө хянана” иргэний
нийгмийн сүлжээнээс:**

“Ил тод байдал сан” ТББ

“Хэрэглэгч сан” ТББ

“Урагш дэвших холбоо” ТББ

Төслийг санхүүжүүлэгч:

“Нээлттэй нийгэм форум” ТББ

АГУУЛГА

I. “2016 ОНЫ НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ ИТХ-ЫН ХУРАЛДААН БА БАРИМТ БИЧГИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
II. МОНИТОРИНГИЙН ЯВЦ.....	5
III. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН.....	14
IV. МОНИТОРИНГИЙН ДҮНГИЙН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	14
V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	16

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын нээлттэй байдал

Хавсралтууд

- 1) Багануур дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 2) Багахангай дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 3) Баянгол дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 4) Баянзүрх дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 5) Налайх дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 6) Сонгинохайрхан дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 7) Сүхбаатар дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 8) Хан-Уул дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо
- 9) Чингэлтэй дүүргийн 2016 оны төсвийн ил тод байдлын товчоо

Товчилсон үгс

ИТХ-Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС-Орон нутгийн хөгжлийн сан
ТББ-Төрийн бус байгууллага
ЗДТГ-Засаг даргын Тамгын газар
БД-Багануур дүүрэг
БХД-Багахангай дүүрэг
БГД-Баянгол дүүрэг
БЗД-Баянзүрх дүүрэг
НД-Налайх дүүрэг
НИТХ-Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХД-Сонгинохайрхан дүүрэг
СБД-Сүхбаатар дүүрэг
ХУД-Хан-Уул дүүрэг
ЧД-Чингэлтэй дүүрэг

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ

I. “2016 ОНЫ НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ ИТХ-ЫН ХУРАЛДААН БА БАРИМТ БИЧГИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэл Улаанбаатар хот ба түүний есөн дүүргийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцсэн ИТХ-ын ээлжит хуралдааны үйл явц болон түүгээр баталсан тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн зорилт, төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны баримт бичгүүдэд ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцооны үүднээс “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний байгууллагууд ажиглалт, мониторинг хийж дүгнэлт зөвлөмж гаргав.

Энэхүү мониторингийг 2015 оны 12-р сараас 2016 оны 2-р саруудад хэрэгжүүлсэн болно.

Мониторингийн хүрээнд орон нутгийн төсвийн дараах үйл явц ба баримт бичгүүдийг хамрууллаа. Үүнд:

- 2015 оны 11,12-р саруудад болсон нийслэл, дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны явц (хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явц)

- Уг хуралдаанд өргөн барьсан 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт, тодотгол, оруулах болон 2016 оны төсвийн төсөл (тэдгээрийн дотор худалдан авах ажиллагаа, орон нутгийн хөгжлийн сан), мөн газар зохион байгуулалтын 2015 оны төлөвлөгөөний биелэлт, 2016 оны төлөвлөгөөний төсөл зэрэг баримт бичиг.

- Хуралдаанаар батлагдсан дээрх албан ёсны баримт бичгүүд.

Мониторингийг хийхдээ урьдчилан төлөвлөгөө гаргаж удирдамж боловсруулан түүний дагуу ажилласан болно.

Мониторингийн төслийг Нээлттэй нийгэм форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэв.

II. МОНИТОРИНГИЙН ЯВЦ

Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын нээлттэй байдал

Төсвийн тухай хуулинд зааснаар нийслэлийн ИТХ-ын хуралдаан 12-р сарын 05-ны дотор, харин дүүргүүдэд мөн 12-р сарын 20-ны дотор хуралдаж төсвөө батлах хуваарьтай учраас өдөр нь тодорхойгүй байсан юм.

Гэтэл зөвхөн нийслэлийн ИТХ хуралдааныхаа товыг өөрийн олон нийттэй харилцах албаар дамжуулан цахим сайтад зарласан бол дүүргүүд энэ талаар

мэдээлэл нийтэд өгсөнгүй. Зарим тохиолдолд ИТХ-ын тэргүүлэгчид хуралдсан тухай мэдээн дунд ИНХ-ийг хэзээ хуралдуулахаар шийдвэрлэсэн тухай мэдээлэл тааралдаж байв.

Дүүргүүдийн ИТХ-ын ээлжит хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг дараах байдлаар мэдээлсэн юм.

Хүснэгт 1. Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын нээлттэй байдал

№	Дүүргийн нэр	Хуралдааныг товыг зарласан өдөр	Хуралдааныг цахим сайтад урьдчилж зарласан өдөр	Хуралдаан болсон өдөр	Эх сурвалж, аль сайтад мэдээлсэн тухай холбоос
1	Багануур	2015.11.30	2015.12.10	2015.12.14	http://baganuur.ub.khural.mn/n/jfnyn
2	Багахангай	-	-	2015.12.14	
3	Баянгол	2015.12.14	-	2015.12.16	
4	Баянзүрх	-	-	2015.12.17	
5	Налайх	2015.12.04	2015.12.09	2015.12.16	http://nalaikh.ub.khural.mn/n/b7nyn
6	Сонгино-хайрхан	2015.12.01	2015.12.07	2015.12.10	http://songinokhairkhan.ub.khural.mn/
7	Сүхбаатар	2015.11.25	2015.11.30	2015.12.10	http://sukhbaatar.ub.khural.mn/n/z3yon
8	Хан-Уул	-	-	2015.12.18	
9	Чингэлтэй	2015.11.26	2015.11.27	2015.12.16	http://chingeltei.ub.khural.mn/

Бас нэг ажиглагдсан зүйл бол өмнөх жилүүдэд ИТХ-ын хуралдаанууд хуулийн эцсийн хугацаанд нэлээн тулгаж, жишээлбэл, урд өдөр нь хуралдах явдал олонтаа байсан бол сүүлийн 2-3 жилд харьцангуй эрт хуралддаг болжээ. Жишээлбэл, нийслэлийн ИТХ-ын хуралдаан 12-р сарын 5-ны дотор хуралдаж төсвөө батлах боломжтой ч 11-р сард багтааж байна. Бид мониторингоо эхэлсэн 12-р сарын 10-ны өдөр гэхэд Сүхбаатар ба Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ууд ид хуралдаж байлаа.

Баянгол дүүргийн ИТХ-ын хуралдааныг 2015.12.13-ын гэхэд товлоогүй байснаа 14-ний ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хоёр хоногийн дараа буюу 16-нд хуралдуулахаар товлосныг ажлын албаны зарим ажилтан мэдэхгүй, эсвэл хэлэхгүй, хаана хуралдах нь тодорхойгүй байв. Бусад дүүргийн товыг ч албан ёсны цахим сайтуудад зарлаагүй учраас арга буюу утасдаж, эсвэл биеэр очиж уулзан мэдэж авч байлаа.

Хуралдаанд суух зөвшөөрөл авсан үйл явц

Өмнөх жилүүдэд зарим дүүрэгт “урьдчилж хэлэх ёстой байсан”, “зөвшөөрөл аваагүй байна” гэх мэт шалтгаанаар төрийн бус байгууллагын төлөөллийг хуралдаанд оруулахгүй тохиолдол гарч байсан тул энэ жил бид албан бичгээр хандсан юм.

2015.12.10-ны өдөр гэхэд Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн хуралдаанууд нэгэнт эхэлсэн байсан тул зөвхөн хуралдааны тэмдэглэл, холбогдох бичиг баримтыг авах хүсэлтийг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийг үндэслэн илгээсэн болно. Харин үлдсэн долоон дүүргийн ИТХ-ын даргын нэр дээр хуралдаанд суух зөвшөөрөл хүссэн албан бичиг хүргүүлсэн. Нэг ч дүүрэг бидэнд албан ёсоор хариу хэлээгүй. Гэхдээ бид албан бичгийнхээ хариуг нэхэх байдлаар утсаар ярьж тайлбарлаж ихэнх тохиолдолд амаар зөвшөөрөл авч чадсан ба тэгж чадаагүй цөөн дүүрэгт манай ажиглагчдыг очиход хуралдаанд суулгахгүй гэж татгалзаагүй, ингээд бүгд оролцож чадсан юм.

Төсвийн төслийн баримт бичгийн ил тод байдал

Мониторингийн явцад хамгийн түрүүнд ажиглагдсан зүйл бол төсвийн баримт бичгүүд батлагдсаны дараа яаж ийгээд олон нийтэд хүрч байгаа боловч батлагдахаасаа өмнө хаалттай хэвээр байв.

Хуралдаанд суусан ажиглагч нар дээр баримт бичгийн төслийг авах хүсэлт гаргахад бараг бүх тохиолдол шууд гаргаж өгдөггүй, “илүү хувь байхгүй, дараа аваарай” гэж тайлбарлаж байснаас үзэхэд хурлын материалыг зөвхөн төлөөлөгчдийн тоогоор хувилж бэлтгэдэг гэсэн ойлголт төрж байна.

Харин хуралдаанаас хойш Чингэлтэй дүүрэг, Багахангай дүүрэг баримт бичгийн төслүүдийг гаргаж өгсөн болно.

Хуралдааны үйл явцад ажиглалт хийсэн тухай

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний төлөөлөл дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны дотоод журамд захирагдаж, ямар нэгэн саад тотгор учруулахгүйгээр ажиглалт хийсэн. Ажлын албаны зүгээс ч бидэнд эхнээс нь дуустал чөлөөтэй ажиглах боломжийг олгов.

Бид хуралдаанд суухдаа бүх үйл явцыг ажиглаж гараар тэмдэглэл хөтлөхөөс зарим тохиолдолд фото зураг авч, бас бүрэн аудио бичлэг хийж авч байлаа.

Хуралдаанд өргөн барьсан буюу төлөөлөгчдөд тараасан илтгэл, танилцуулга, төсвийн төслийн баримт материалуудыг үзэж танилцах боломж байгаагүйг дээр хэлсэн.

Хуралдаанаар баталсан баримт бичгүүдийг олж авах үйл явц

ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж санал хурааж баталсан баримт бичгүүдэд төлөөлөгчдийн саналыг тусгаж редакцийн засвар хийж бэлэн болгосны дараа буюу хуралдаанаас хойш 7 хоногийн дараа гэх мэт тодорхой хугацаанд олон нийтэд хүргэхээр хуулинд заасан байдаг.

Бид тэр хугацаа өнгөрмөгц дүүргийн цахим сайтаас олж авахын тулд эрж хайсан ба олдоогүй тохиолдолд амаар болон албан бичгээр хүсэлт тавьж ажиллав.

Батлагдсан төсвийн баримт бичгүүд хуралдаанаас хойш арваад хоногоос эхлээд хоёр сарын дотор тухайн дүүргийн албан ёсны цахим сайтуудад ээлж дараалан тавигдсаар үндсэндээ гүйцсэн юм. Зарим материалыг ИТХ-ын ажлын албанаас манай ажиглагчид хүсэлт тавьж аваад сайтдаа нийтэлсэн болно. Харин газар зохион байгуулалтын холбогдолтой шийдвэрүүд илүү удаж нээлттэй болох буюу заримдаа одоо ч ил тод болоогүй байна.

Бидний хувьд хамгийн чухал баримт бичиг бол тухайн ИТХ-ын хуралдааны албан ёсны тэмдэглэл бөгөөд танхимд болсон үйл явдал, хэлсэн ярьсныг тэмдэглэлд хэр үнэн зөв, бүрэн тусгасныг манай ажиглагчид өөрсдийн бичлэг, тэмдэглэлтэй харьцуулж үзэхээс гадна олон нийтэд нээлттэй болгохыг хүссэн юм.

Урьд жилүүдийн туршлагаас үзэхэд ИТХ-ын хуралдааны тэмдэглэл ил тод болж байсан тохиолдол маш ховор, харин “Иргэд төсвөө хянана” сүлжээнээс хэрэгжүүлсэн өмнөх мониторингийн хүрээнд зарим аймгийн хуралдааны тэмдэглэлийг авч нийтэлж байсан.

Энэ удаад ч гэсэн хуралдааны тэмдэглэлийг олж авах нь 2-3 дүүргээс бусдад маш ихээхэн түвэгтэй байсан тул бид арга буюу “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу дахин дахин албан бичгээр хандахад хүрч байлаа. Тодруулбал, дүүргүүдийн хуралдааны тэмдэглэл, болон батлагдсан баримт бичгүүдийг авах хүссэн албан бичгийг 2015.12.22, 2016.01.11, 2016.01.29-ний өдрүүдэд нийт 16 удаа (зарим дүүрэг рүү нэг, зарим дүүрэг рүү 2-3 удаа) явуулахад Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай, Налайх дүүрэг шууд, Баянзүрх дүүрэг хэсэг хугацааны дараа тус тусын тэмдэглэл, зарим материалыг ирүүлсэн болно.

Хэд хэдэн дүүргийн ИТХ-ын ажлын албаны хүмүүс уг тэмдэглэлийг өгөхөө татгалзаж буйгаа амаар мэдэгдсэн тул бид ингэх нууцлах болсон хууль эрх зүйн тодорхой үндэслэлээ тайлбарлах, хэрвээ байгууллагын нууцын жагсаалтанд орсон бол тэр жагсаалтаа гаргаж өгөхийг хүсэхэд янз бүрийн аргаар булзайруулсаар өнгөрүүлсэн юм.

Мониторингийн явц, үр дүнг нийслэл ба 9 дүүрэг тус бүрээр товч танилцуулбал дараах байдалтай байна.

Нийслэл Улаанбаатар хотын ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Монгол Улсын төсвийн тухай хуулиар Нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа өргөн мэдүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах учиртай ч лав сүүлийн хоёр жил дараалан 11-р сардаа багтаан хуралдлаа. Энэ удаад уг үйл явц дараах байдлаар өрнөв.

2015.11.18-нд нийслэлийн иргэний танхимд 2016 оны төсвийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж дүүргүүдийн төр захиргааны байгууллагын ажилтнууд, мөн хороод, зарим төрийн бус байгууллагын төлөөлөл оролцжээ. Хэлэлцүүлэгт Нийслэлийн Засаг даргын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

2015.11.23-нд нийслэлийн ИТХ-ын ээлжит 31 дүгээр хуралдаан болж нийслэлийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийг батлах, 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэх байсан ч уг хурал дахь МАН-ын бүлэг эдгээр асуудалтай дэлгэрэнгүй танилцаагүй учраас хэлэлцүүлэгт оролцох боломжгүй гэж үзээд ажлын гурав хоногийн завсарлага авсан тул хуралдааны дэгийн дагуу энэ сарын 26-ны өдөр буюу Пүрэв гарагт дахин хэлэлцэхээр болж хойшлуулсан.

2015.11.24-нд нийслэлийн ИТХ-ын ээлжит 32 дугаар хуралдаан болж нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын хэрэгжилт, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилт, Нийслэлийн өмчөөс 2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт, 2014, 2015 оны хувьчлалын жагсаалтаас хасах тухай, Нийслэлийн өмчийн концессын жагсаалт, Нийслэлийн 2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн 2016 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, нийслэлийн 2016 оны төсвийн анхны хэлэлцүүлгийг хийсэн ба дуусгаж амжилгүйгээр Даваа гарагт үргэлжлүүлэн хэлэлцэхээр болж тарсан байна

2015.11.26-ны өдөр ИТХ-ын өмнөх 31 дүгээр хуралдааны үргэлжлэл болж Нийслэлийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн тодотголыг хэлэлцэж батлав.

2015.11.30-нд нийслэлийн ИТХ-ын ээлжит 32 дугаар хуралдаанаар үргэлжилж нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын биелэлт, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилт, Нийслэлийн 2016 оны төсөв, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, нийслэлийн өмчөөс 2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг хэлэлцэн баталлаа.

Дээрх дөрвөн удаагийн хуралдааныг нийслэлийн UBS телевизээр ерөнхийдөө шууд дамжуулсан тул манай хүмүүс телевизээр үзжэ ажигласан юм. Харин хуралдаан завсарлаж сунжрахад бас хойшилсны дараа шууд дамжуулалт хоцрох, тасрах явдал ажиглагдсан болно.

Багануур дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Тус дүүргийн төсвийн баримт бичгүүдийг 12-р сарын 9-ны өдөр буюу хуулийн хугацаанд багтаан дүүргийн Засаг дарга Б.Бямбадорж ИТХ-ын дарга Р.Өнөржаргалд өргөн барьсныг тэр өдөртөө дүүргийн цахим сайтад нийтэлсэн нь бусад дүүрэгт гараагүй онцлог мэдээл болсон юм.

Бид тус ИТХ-ийн сайтаас харилцах утасны дугаар олоогүй, гэхдээ цахим хаяг байсан тул албан бичгээ цахимаар явуулсан ба хуралдааны өдөр - 2015.12.14-нд “Ил тод байдал сан” ТББ-ын ажилтан Б.Бямбасүрэн очиход ямар нэгэн саадгүйгээр хуралдаанд сууж ажиглах, бичлэг хийх боломж олгосон болно.

Хурлын тэмдэглэлийг ямар нэгэн албан бичиг, тайлбар шаардахгүйгээр и-мэйлээр ирүүлсэн. Харин хуралдааны үеэр хэлэлцэж буй асуудлын төслийг авах хүсэлт тавихад ажлын албаны зүгээс татгалзаагүй, авахыг зөвшөөрч байлаа. (Харамсалтай нь хуулж авсан файлууд алдаа заагаад нээгдээгүй юм)

Уг хуралдаанаас баталсан баримт бичгүүд албан ёсны сайтуудад тавигдсан тул тэндээс авч мониторингт хамрууллаа.

Багахангай дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Бид тус дүүрэг рүү утсаар холбогдож хуралдааныг ажиглах хүсэлт тавихад шууд зөвшөөрсөн болно.

Хуралдаан 2016.12.14-нд болж “Иргэд төсвөө хянана” сүлжээг төлөөлөн Б.Лхагвасүрэн очиж ажиллав. Хуралдааны үйл ажиллагаа ихээхэн нээлттэй болж аудио бичлэг хийж гэрэл зураг авсан байна.

Төлөөлөгчдөд тараасан зарим материалын илүү хувийг ажиглагчид шууд өгсөн ба дараа нь хурлын тэмдэглэлийг и-мэйлээр, харин батлагдсан төсвийн баримт материалуудыг хүнээр ирүүлсэн. Харин газар зохион байгуулалтын төлөвлөгөөнийн биелэлт төсөл, батлагдсан төлөвлөгөөг сайтад байршуулаагүй хэвээр байна.

Баянгол дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Тус дүүргийн ИТХ-ын ээлжит хуралдааны товыг мэдэх нь ихээхэн хүндрэлтэй байж, бидний зүгээс холбоо барьж мэдээлэл авсан хурлын ажлын албаны хэд хэдэн эх сурвалж зөрүүтэй мэдээлэл өгч байв. Хуралдаан 2015.12.18 нд болсон ба урьд өдрийнх нь орой тус хуралдаан хэзээ хаана болох талаар эцэслэн шийдэгдээгүй мэтээр хариулж байв.

“Хэрэглэгч сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Оюунтуяа хурлын хэд хэдэн төлөөлөгчөөс танилын журмаар асууж захиж байж урьд орой нь мэдэж аваад очиж оролцсон юм.

Хуралдаанд ажиглалт хийхэд хүндрэл учраагүй.

Харин хуралдаанаас баталсан төсвийн баримт бичгүүд болон албан ёсны тэмдэглэлийг авахын тулд хэд хэдэн удаа албан бичиг явуулж, хойноос нь хэд хэдэн удаа утсаар лавлахад ИТХ-ын ажлын албаны захиргаа, хуулийн хэлтсийн ажилтан “Манайх нүүдэл суудал таараад тэр олон 100 хуудас материалыг

олшруулахад хэцүү байна” гэсэн тул бид файлаар, эсвэл хүн явуулаад авахад бэлэн гэдгээр хэлсэн ч өгөхгүй байв.

Бид дахин лавлахад “шуудангаар явуулсан” гэж хэлсэн ч худлаа байсан (“Улаанбаатар шуудан” компани тийм албан бичиг хүлээж аваагүй гэж мэдэгдсэн) тул бид дахиж хоёр удаа шаардаад энэ оролдлогоо орхисон болно.

Харин төсвийн ганц нэг баримт бичгийн хуулбарыг өгсөн юм.

Баянзүрх дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Хуралдаан 2015.12.17-ны өдөр 15.00-17.15 цагийн хооронд маш шуурхай хуралдсан. Хуралдаанд 41 төлөөлөгчөөс 27 төлөөлөгч оролцжээ.

Хуралдааны дараа хурлын тэмдэглэлийг авах хүсэлтийг амаар тавихад “байгууллагын нууц” гэсэн тайлбарыг хурлын ажлын албаны ажилтан хэлж цааргалсан. Бид утсаар ярьж, хүн явуулж уулзан, бас албан бичиг явуулсны дараа хуралдааны тэмдэглэлийг шуудангаар ирүүлсэн.

Хуралдаанаар хэлэлцүүлсэн баримт бичгийн төслүүдийг ажиглагч Ц.Отгонсүрэнд өгсөн болно.

Харин батлагдсан баримт бичгүүдийг албан ёсны сайтуудад бүрэн байршуулаагүй.

Налайх дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Хуралдаанд сууж ажиглалт хийх хүсэлт тавьсан албан бичгийг и-мэйл хаягаар явуулаад утсаар тодруулахад зөвшөөрсөн ба 2015.12.16-ны Лхагва гаригт 09-15 цагт болсон хуралдаанд Д.Цэрэнжав сууж ажиглалт хийхэд ямар нэгэн хүндрэл учраагүй.

Хуралдаанаар хэлэлцүүлсэн баримт бичгийн төслүүдийг ажиглагчид өгөөгүй.

Хуралдааны дараа албан бичиг явуулахад хуралдааны тэмдэглэлийг хэд ямар нэгэн асуудалгүйгээр ирүүлсэн ба батлагдсан баримт бичгүүдийг хэсэг хугацааны дараа дүүргийн албан ёсны болон www.khural.mn сайтад бүрэн байршуулсан.

Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

2015.12.10-нд болсон тус дүүргийн ИТХ-ын хуралдаанд оролцож амжаагүй юм.

Хурлын тэмдэглэл, материалыг олж авахаар “Шинэ хамтрал” ТББ-ын тэргүүн П.Нямдорж ажиллаж амаар хүсэлт тавихад өгөөгүй тул албан бичгээр авах

хүсэлт тавьж хандахад өгөөгүй. Иймд дахин “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн холбогдох заалтыг сануулж дахин албан бичгээр хандсан боловч утсаар албан тушаалаа хэлээгүй ажилтан Мөнхбаяр “өгөх боломжгүй” гэж хэлсэн. Бид дахин бичиг явуулж ядахдаа өгөхгүй байх эрх зүйн үндэслэл, шалтгааныг тайлбарлахыг хүсэхэд ямар нэгэн хариу ирүүлээгүй өнгөрсөн болно.

Одоогоор зөвхөн 2016 оны батлагдсан төсөв, 2015 оны төсөвт тодотгол хийсэн ИТХ-ын тогтоол ил тод болсон байна.

Сүхбаатар дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

2015.12.10-нд болсон тус дүүргийн ИТХ-ын хуралдаанд оролцож амжаагүй тул хуралдааны тэмдэглэл авахыг хүссэн албан бичгийн дагуу хурлын тэмдэглэлийг ирүүлсэн.

Хуралдаанаар батлагдсан баримт бичгүүдийг цахим сайттай байршуулсан байсныг нь татаж авч мониторингдоо хамруулсан.

Хан-Уул дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Хуралдааны товыг ажлын албанаас утсаар лавлаж мэдсэн болно.

2015.12.18-ны 10-15 цагийн хооронд хуралдсан уг хуралдааныг Б.Бямбасүрэн ажиглаж бичлэг хийх, зураг авахад ямар нэгэн хүндрэл учраагүй.

Харин амаар хүсэлт тавихад хуралдааны тэмдэглэлийг өгөөгүй тул албан бичгээр хандсан. Албан бичгийн хариунд, тус хурлын ажлын албаны байранд очиж хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болох тухай бичсэн байлаа.

Үүний дагуу очиход, тухайн хурлын тэмдэглэлийг түргэн уншихыг шаардаж, бас зөвхөн эхний ба сүүлчийн хуудасны зургийг авахыг зөвшөөрч, харин бүрэн эхээр нь хуулбарлах юмуу зургийг авахыг зөвшөөрөөгүй.

Ингэх болсон шалтгааныг тодруулахад, тус ИТХ-ын ажлын албан дарга Б.Бас-Оргил байгууллагын нууцтай холбогдуулж тайлбарласан.

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал

2015.12.18-нд болсон тус дүүргийн ИТХ-ын хуралдаанд “Урагш дэвших холбоо” ТББ-ны тэргүүн Н.Сувд ажигласан.

Хуралдааны товыг мэдэж авах, сууж ажиглалт хийх, дараа нь батлагдсан баримт бичгүүдийг авахад ямар нэгэн хүндрэл учраагүй ба хуралдааны тэмдэглэлийг ямар нэгэн албан бичиг шаардалгүй амаар гаргасан хүсэлтийн дагуу гаргаж өгсөн болно.

(Бидний сууж ажиглалт хийсэн нийслэл ба зарим дүүргийн ИТХ-ын хуралдаан 2015 оны төгсгөл, 2016 оны эхээр дахин хуралдаж гол төлөв 2015 оны төсөвт тодотгол хийсэн байна. Гэхдээ бид тэдгээрийн тухай мэдээллийг цуглуулснаас биш мониторинг хийгээгүй юм)

III. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

Бид мониторингийн явцад хийсэн ажиглалт, тэмдэглэл, олж авсан баримт бичгүүдийн материал нотолгоонд тулгуурлан “2016 оны төсвийн мэдээллийн ил тод байдлын товчоо”-г нийслэл болон дүүрэг тус бүрээр гаргасан болно. Энэ бол тухайн дүүргийн 2016 оны төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал ямар байсныг нэг хавтгайд нэгтгэн харуулсан загвар юм.

(Дүүргүүдийн ил тод, нээлттэй байдлын товчоог хавсаргав)

Дээрх товчоо, бас ил тод болгосон төсвийн үндсэн баримт бичгийг “Иргэд төсвөө хянана” сүлжээний www.tusuv.mn нэгдсэн цахим сайтын “Орон нутгийн төсвийн мониторинг” дэд сайтад шинээр байршуулж олон нийтэд нээлттэй болголоо. Тэдгээрийн нэлээд нь нийслэл, тухайн дүүргийн албан ёсны сайтууд болон иргэдийн хурлын www.khural.mn нэгдсэн сайтад тавигдсан баримт бичгүүд, харин бусад нь нь тавигдаагүй буюу бидний хүсэлт тавьж авсан хуралдааны тэмдэглэл, мөн цаасаар олж авсан баримт бичгийн сканнердсан хуулбарууд юм. Өөрөөр хэлбэл анх удаа ил тод болсон гэсэн үг.

Уг мониторинг нь нийслэл, Улаанбаатар хот ба түүний есөн дүүргийн ИТХ-аар 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах үйл явцад хөндлөнгийн хяналт болсон ач холбогдолтой юм. Мөн Багануур, Багахангай, Налайх дүүргийг анх удаа энэхүү мониторингт хамруулав.

Бас “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагуудын хувьд орон нутгийн төсвийн үйл явцыг таньж мэдэх, оролцох ээлжит бодитой туршлага боллоо.

Мониторингийн үр дүнд нийслэл, дүүргийн төсвийн үндсэн баримт бичгүүдийг бодитойгоор ил тод болгож нэг сайтад байршуулснаас гадна хэд хэдэн дүүргийн хуралдааны тэмдэглэлийг анх удаа нээлттэй болгож чадлаа.

IV. МОНИТОРИНГИЙН ДҮНГИЙН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Мониторингийн үр дүнгийн хэлэлцүүлгийг 2016 оны 4-р сарын 8-нд Нээлттэй Нийгэм Форумын хурлын танхимд зохион байгуулсан билээ.

Хэлэлцүүлэгт зарим дүүргийн ЗДТГ-ын ажилтан, төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 30 шахам хүн оролцож Б.Бямбасүрэн ИТХ-ын хуралдаанд сууж ажиглалт хийсэн, хуралдааны тэмдэглэлийг хэрхэн олж авсан талаар, Д.Цэрэнжав 2016 оны төсвийн баримт бичгийн ил тод нээлттэй байдлын талаар тус тус танилцуулга хийлээ.

Удирдлагын академийн багш, доктор Л.Отгонтуяа мониторингийг нэгтгэн дүгнэж, орон нутгийн төсвийн үйл явц, эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлыг тодорхой баримт жишээгээр тайлбарлав.

Дараа нь хэлэлцүүлэгт оролцогсод байр сууриа илэрхийлж санал шүүмжлэл өрнүүлэв.

V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нийслэл Улаанбаатар хот ба түүний 9 дүүргийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын ээлжит хуралдааны үйл явц болон түүгээр баталсан баримт бичгүүдэд ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцооны үүднээс хийсэн мониторингийн үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Аливаа төсвийн төлөвлөгөө, төсөл зэргийг аль болох эрт, урьдчилан нээлттэй болгож, иргэд, оршин суугчид, татвар төлөгчид, салбар мэргэжлийн төлөөлөл, шинжээчдийн оролцоотойгоор яриа хэлэлцүүлэг өрнүүлж байх

Орон нутгийн төсвийн үйл явцад иргэд, оршин суугчдын оролцоог зөвхөн орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөр, ажил үйлчилгээ, арга хэмжээний төлөвлөгөөнд санал авахаар хязгаарлаж байгаа нь хангалтгүй болжээ. Учир нь ОНХС-аас бусад төсөв иргэдийн оролцоо орхигдож, хяналтаас гадна үлдэх хандлагатай байна.

Тухайлбал, орон нутгийн төсвийн төлөвлөгөө, Засаг даргаас Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьсан төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, газар зохион байгуулалт, концесс, хувьчлалын баримт бичгийн төслүүд хаалттай байгаа учраас иргэд саналаа хэлэх боломж бүрдэхгүй байна. Төсвийн төслийг хүлээж аваад ИТХ дахь намын бүлэг, түүний ажлын хороо, хэсэг болон төлөөлөгчид ямар өөрчлөлт хийж хуралдаанд танилцуулсныг харьцуулан үзэх боломж алга байна.

Иймд нийслэл, дүүргийн төсвийн төлөвлөгөө, төслийг боловсруулж үе шат болгонд мэдээлэл өгч нээлттэй болгох шаардлагатай.

Ялангуяа өнөөдөр төсөв болж томъёологдоогүй ч цаашдаа хөрөнгө, мөнгө шаардах янз бүрийн мөрийн хөтөлбөр, амлалтаас эхлээд төлөвлөгөө, төслийг шийдвэр гаргахаас өмнө иргэд, оршин суугчид, татвар төлөгчид, шинжээчдээр байнга хэлэлцүүлж байх нь улам бүр чухал болжээ. Энэ нь төсөв хөрөнгийг нэгэнт зарцуулахаар төлөвлөсөн, эсвэл баталсан хойно ардаа олон тэгтэй тоог иргэдээр хэлэлцүүлэхээр илүү үр дүнтэй гэж үзэж байна. Нэгэнт батлагдсан төсвийг зөв, буруу, сайтар нягталж тооцоолж чадсан эсэхээс үл хамааран хэрэгжүүлэх л үлдэж байгаа билээ.

Ер нь төсвийн томоохон зарцуулалт, худалдан авалт, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын томоохон ажлыг төсөв мөнгө ярихаасаа өмнө хэрэгцээ, шаардлага, нийгэм-эдийн засаг, байгаль орчны нөлөөлөл, үр дагаврын талаас нь олон нийтийн оролцоотой хэлэлцэж эцэслэдэг байх, шинэ бүтээн байгуулалт буюу хөрөнгө оруулалт, худалдан авалтаар бий болгосон дэд бүтэц, зам, барилга зэрэг объектууд дараа нь байнгын зардал шаарддаг болохыг анхаарах хэрэгтэй байна. Ингэснээр тухайн асуудлаар илүү оновчтой шийдлийг олох, иргэдийн дунд зөвшилцөл бий болох, тэдний дэмжлэг авах ач холбогдолтой юм. Бодит байдал

дээр тухайн асуудлыг сайн мэддэг хүн, эсвэл чухал мэдээлэлтэй хүн заавал шийдвэр гаргагчдын дунд байх албагүй.

Мэдээжийн хэрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх болон зарцуулахад иргэдийн саналыг авч хэлэлцүүлэх үйл явц үргэлжлэх ёстой.

Хоёр. ИТХ-ын хуралдааны товын тухайд

Орон нутгийн ИТХ-ын хуралдааны тов, хэлэлцэх асуудлын талаар аль болох эрт зарлаж байх нь нийслэл, тухайн оршин суугчид шууд болон өөрсдийн сонгосон төлөөлөгчдөөр дамжуулан саналаа илэрхийлж амжих, идэвхтэй иргэд, иргэний нийгмийн байгууллагууд бидний нэгэн адилаар ажиглалт, мониторинг хийх чухал нөхцөл юм.

Монгол Улсын Төсвийн тухай хуулиар нийслэлийн Засаг дарга төсвийн төслийг 11-р сарын 25-ны дотор ИТХ-даа өргөн мэдүүлж, 12-р сарын 05-ны дотор хэлэлцэн батлах, харин дүүргийн Засаг дарга 12-р сарын 10-ны дотор өргөн мэдүүлж 12-р сарын 20-ны иргэдийн ИТХ-аар хэлэлцэн батлахаар заасан байдаг. Харин 2016 оны төсвийн тухайд нийслэлийн ИТХ 11-р сарын 23-30-ны хооронд хуралдаж дууссан бол Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийнх 12-р сарын 10-ны өдөр төсвөө хэлэлцэж баталжээ.

Төсвийн төслийг эртхэн баталснаар хуралдаанаас гарсан саналыг тусгах, хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчилан боловсруулаад 2016 оны 1-р сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг хангахад тустай боловч хуулиар олгосон цаг хугацааны боломжийг төсөв, худалдан авах ажиллагаа, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл зэрэг баримт бичгийг иргэд, оршин суугчиддаа хүргэж тэднээр хэлэлцүүлж саналыг авч тусгахад ашиглахыг санал болгож байна. Тухайлбал, нийслэл, дүүргийн ИТХ-ны төлөөлөгчид төсвийн баримт бичгийн төслийг аваад тус тусын сонгогдсон тойрогт очиж иргэд, сонгогчидтойгоо уулзалт зохион байгуулж танилцуулах, тэдний саналыг сонсч цааш уламжлах зэргээр ажиллах боломж гэж үзэхийг уриалж байна.

Энэ бол ИТХ-ын төлөөлөгчид иргэддээ ажил хэрэгчээр хандаж бодитой яриа өрнүүлэх цөөхөн боломжийн нэг юм.

Төсвийн төслийг өргөн барьснаас хойш ИТХ-ын хуралдаанд оруулах хүртэл ИТХ дахь намын бүлэг, ажлын хэсэг, хороод ажилладаг боловч тэр хугацаа тэртээ тэргүй богино байдаг учраас уг хэлэлцүүлэг хэрхэн явагдаж ямар санал гарсан, юуг өөрчилсөн, хэрхэн зөвшилцсөнийг огт мэдэхгүй, тийм боломж гарахгүй байсаар өнгөрч байгааг анхаарах хэрэгтэй.

ИТХ-ын хуралдааны тов тодорхойгүй байх, хэт урагшлуулж хуралдсанаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд заасанчлан "24.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны

Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно” гэсний дагуу санаачлага гаргах боломжийг олгохгүй байна.

Нийслэл Улаанбаатар хотын ИТХ-ыг эс тооцвол дүүргүүдийн ИТХ-ын товыг өргөн олон нийтэд хүртээмжтэйгээр зарлаж байх шаардлагатай.

Гурав. ИТХ-ын хуралдааны үйл явц

Нийслэл, дүүргийн ИТХ-ын хуралдаан, тэр тусмаа дараа жилийн төсөв, худалдан авалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах хуралдаан бол орон нутгийн иргэд, сонгогчдод нээлттэй байх ёстой онцгой үйл явдал юм.

Ийм учраас Улаанбаатар хотын ИТХ-ын хуралдааныг телевизээр шууд дамжуулж байгаа нь сайшаалтай. Харин дүүргүүдэд тийм боломж байхгүй ч нээлттэй байдлыг хангах боломжтой гэж үзэж байна.

Ажиглалтаас үзэхэд ИТХ-ын ээлжит хуралдааныг хаана ч албан ёсоор хаалттай гэж зарлаагүй, хүсэлт тавихад суухыг зөвшөөрч байсан хэдий ч бараг бүх дүүрэгт тухайн дүүргийн иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцоогүй, уригдаагүй төдийгүй огт мэдээгүй байлаа. Хуралдааны өдөр ч гэсэн уг хуралдааны талаарх ямар нэгэн зарлал, анонс ихэнх дүүргийн төр, захиргааны байгууллагын байранд тавигдсангүй.

ИТХ-ын хуралдааны дэгийг илүү тодорхой болгож ягштал баримтлах шаардлагатай. Учир нь зарим дүүргийн хуралдааны танхимд илтгэгч болон санал хэлж буй төлөөлөгчийн сэдэв, нэр, албан тушаалыг албан ёсоор бүтэн зарлахгүй байх, жишээлбэл, хурал даргалагч “Одоо чи ярь” “Баяраа дарга яриарай” гэх мэтээр харилцаж байгаа нь тэд бие биенээ таньдаг учраас хоорондоо шууд ойлголцсон байж болох ч хөндлөнгийн ажиглагчдын хувьд ямар албан тушаалтай хэн болохыг мэдэхэд хүндрэлтэй төдийгүй хэт задгай, эмх цэгцгүй уур амьсгалыг бүрдүүлж байна. Эсвэл зарим төлөөлөгч зөвшөөрөл авахгүйгээр “Би нэг юм хэлээдэхье” гэх мэтээр хэлэлцүүлэгт оролцож байна. Хурлын дэгийг хэрхэн баримтлах тухайд УИХ-ын чуулганы хуралдаанаас үлгэр жишээ авах шаардлагатай.

Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн нэлээд нь Засаг дарга, орлогч, харъяа байгууллагын дарга зэрэг гүйцэтгэх албан тушаалтнууд байсан нь “давхар дээлний асуудал” орон нутагт ч чухал болохыг харуулав. Үүнээс болж иргэдийн төлөөлөгч болон гүйцэтгэх албан тушаалтны зааг ялгаа бүдгэрч, нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс Засаг дарга болон ЗДТГ-ын албан тушаалтнуудтай хариуцлага тооцож шаардлага тавьсан байр суурь намын бүлгүүд хоорондын зарим зөрчилдөөнийг эс тооцвол үгүйлэгдэж байсныг хэлэх хэрэгтэй.

Дүүргийн ИТХ-ын хуралдаан ганц өдөрт төдийгүй хагас өдөр, хэдхэн цагт багтан хуралдаж байгааг төлөөлөгчид баримт бичигтай урьдчилан сайн танилцсан, намын бүлэг, хурлын хороод сайн ажилласан гэдгээр тайлбарлаж болох ч

тодорхой асуудлыг яагаад ингэж буюу тэгж шийдсэн нь гүйцэт ойлгогдохгүй өнгөрч байна. Зарим хуралдаан дээр нэг ч асуулт гарахгүй, санал шүүмжлэл өрнөхгүйгээр төсвөө баталжээ. Ингэж дүүргийн ажил, амьдралын үндсэн баримт бичиг болсон төсвийн хэлэлцүүлэг ёслол төдий болсныг сайшаах аргагүй юм.

Дөрөв. Хуралдааны тэмдэглэл

Нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага - хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр болсон хуралдаан, тэр тусмаа төсөв, санхүү, худалдан авалт, газар зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж баталсан ИТХ-ын ээлжит хуралдааны тэмдэглэлийг ил тод болгох нь мониторингийн чухал зорилго байсан юм.

Уг тэмдэглэлийг нууцлах ямар ч үндэслэл байхгүй бөгөөд уг хуралдаанд сууж ажиглах боломжгүй иргэд, оршин суугчид хуралдааны тэмдэглэлээс өөрсдийн сонгосон төлөөлөгчид хуралдаанд хэр идэвхтэй оролцсон, ямар байр суурь илэрхийлж, хэр оновчтой санал дэвшүүлсэн, эрх ашгийг нь хамгаалсан эсэхийг мэдэж авах ач холбогдолтой маш чухал баримт бичиг гэж бид үзсэн юм.

Дүүргүүдийн тэн хагас нь энэхүү хуралдааны тэмдэглэлийг шууд буюу эхний хүсэлтийн дагуу нээлттэй болгосон бол бусад нь хууль эрх зүйн тодорхой үндэслэлгүй шалтаг, шалтгаан зааж гаргаж өгөөгүй юм.

Иймд ИТХ-ын хуралдааны албан ёсны тэмдэглэл бэлэн болмогц ямар нэгэн болзол, шалтаггүйгээр нийтэд дэлгэж байх шаардлагатай. Үүний дараа ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрээс гадна тэмдэглэлийг нээлттэй болгох асуудлыг авч үзэх шаардлагатай.

Үйл явцаас харахад ямар асуудлыг ИТХ-ын, ямар асуудлыг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдэх нь иргэд, сонгогчдад ойлгомжгүй, жишээлбэл ИТХ-аар баталсан асуудлыг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар өөрчилж шийдвэрлэх явдал ажиглагдлаа. Үүнийг нарийвчлан зохицуулах буюу энэ талаар иргэдэд тодорхой ойлголт өгөх шаардлагатай.

Тав. Батлагдсан төсвийн ил тод, нээлттэй байдал

Орон нутгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж баталсан төсвийн холбогдолтой тогтоол шийдвэрийг тодорхой хугацаанд юуны өмнө албан ёсны цахим сайтаар нээлттэй болгохоор хуулинд заасан боловч яв цав хэрэгжүүлэхгүй хэвээр байна.

Ажиглахад, төсвийн мэдээллийн цахим сайтад хэрхэн байршуулах жишиг стандарт байхгүй, хэрвээ байдаг бол түүнийг баримталдаггүй учраас нийслэл, дүүргийн болон бусад цахим сайтын өөр өөр булан, цэсэнд, doc, зургийн, эсвэл pdf зэрэг өөр өөр форматаар хамаа намаагүй байршуулдаг учраас жирийн иргэн олж үзэхэд түвэгтэй байна.

Нийслэлийн дүүргийн сайтууд дизайны хувьд өөр өөр байж боловч үндсэн бүтэц, ангилал, цэсүүд ижил байх ёстой гэж үзэж байна.

Нийслэл, дүүргийн төсөвтэй хамт ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж баталдаг газар зохион байгуулалтын төлөвлөгөө ба гүйцэтгэл, орон нутгийн өмчөөс хувьчлах жагсаалт зэрэг нь олон нийтийн анхааралд өртөхгүй байна. Энэ нь уг асуудалд иргэд, олон нийтийг оролцуулахыг төдийлөн хичээдэггүй, тэдэнд урьдчилан танилцуулж яриа хэлэлцүүлэг, өрнүүлэхээс зайлсхийж ирсэн олон жилийн зуршил гэж ойлгогдсон болно.

Зургаа. Төсвийн баримт бичгүүдийн мэдээллийн сан

Орон нутгийн төсөв, санхүүгийн мэдээллийг хадгалж байх зорилт шинээр тавигдаж байна. Учир нь цахим сайтыг загвар, дизайныг өөрчлөх, эсвэл улс төрийн сонгуулиар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, албан тушаалтнууд солигдсоны дараа сайт шинээр хийгдэж өмнөх төсөв, санхүүгийн мэдээлэл алга болж байна. Өнөөдрийн байдлаар зөвхөн Налайх дүүрэг хуучин сайтаа хадгалан үлдсэн ба үзэх боломжтой байна.

Сүүлийн үед нийслэлийн Засаг даргын захирамжийг www.ulaanbaatar.mn сайтад, Засаг даргынхаас гадна ИТХ-ын тогтоол, мөн дүүргүүдийн захирамж тогтоолыг www.ublegal.mn сайт буюу нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн санд төвлөрүүлж, ингэхдээ урьд жилүүдийн тогтоол шийдвэрийг нөхөн оруулж байгаа нь нааштай эхлэл юм. Гэхдээ захирамж, тогтоолоос бусад төсөв, санхүүгийн мэдээллийг хадгалах, архивлаад далд хийх биш, байнга нээлттэй байлгах ялангуяа 2016 оны орон нутгийн сонгуулийн өмнө нийслэлээс гадна дүүргүүд санаачлага гарган анхааралдаа авах хэрэгтэй. Юуны өмнө төсвийн мэдээллийг бүртгэж, жагсаалт товъёог гаргах, өгөгдлийн сан байгуулах зэргээр интернэт, мэдээллийн технологийн боломжийг дээд зэргээр ашиглах нь зүйтэй.

Дашрамд дурдахад “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ сүүлийн хэдэн жилийн нийслэл, дүүргийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг тасралтгүй цуглуулж мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байгаа болно.

Долоо. Цаашдын үйл ажиллагаа

Дээрх зөвлөмжийг нийслэл, дүүргийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн болно.

“Иргэд төсвөө хянана” сүлжээний хүрээнд цаашдаа орон нутгийн төсвийн үйл явц ба баримт бичгийн ил тод, нээлттэй байдалд хийх мониторингийн ажлыг шинэлэг арга хэлбэрээр үргэлжлүүлэн явуулах юм.

БАГАНУУР ДҮҮРГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТОВЧОО
(ИТХ-ын хуралдааны үйл явц ба баримт бичиг)

Төсвийн үйл явц ба баримт бичиг		Иргэд, оршин суугч, сонгогчдод хэрхэн ил тод, нээлттэй байсан
ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ		
Дүүргийн 2016 оны төсвийн төлөвлөгөө		-
Дүүргийн 2016 оны төсвийн төсөл (Төсвийн тухай хуулиар, 2015.12.10-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлсэн)		2015.12.09-нд Төсвийн төсөл өргөн барьж буй тухай http://baganuur.ub.khural.mn/ сайтад мэдээлсэн байв. Өргөн барьсан төслийн материалууд байгаагүй.
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНЫ ҮЙЛ ЯВЦ БА БАРИМТ БИЧИГ (2015.12.20-ны дотор хуралдсан)		
Дүүргийн ИТХ-ын хуралдааны үйл явцын ил тод, нээлттэй байдал		
Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	http://baganuur.ub.khural.mn/ цахим сайтад урьдчилж байршуулсан байсан. - Дүүргийн ИТХ-ын мэдээллийн самбарт мөн байршуулсан байсан.	
Багануур дүүргийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө - Багануур дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хугацааны мөрийн хөтөлбөр, 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт - Дүүргийн 2016 оны эдийн засаг, нийгмийн зорилтыг хэлэлцэж батлах тухай - Дүүргийн 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай - Дүүргийн 2016 оны төсвийн төсөл хэлэлцэж батлах тухай - Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай - Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай		
Телевиз, радиогоор шууд дамжуулсан	- Шууд дамжуулаагүй. - ИТХ-ын хуралдааны танхимын үүдний дэлгэцээр харуулж байсан ч сүүлдээ энэ нь тасарсан. - ЗДТГ-ын хэвлэлийн ажилтан видео бичлэг хийсэн.	
Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлчдийг оролцуулсан	Мэдэхгүй	
Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг ажиглагчаар оролцуулсан	“Иргэд төсвөө хянана” сүлжээний төлөөллийг ажиглалт хийлгэсэн.	
Дүүргийн ИТХ-ын хуралдаанд өргөн барьсан, ИТХ-ын төлөөлөгчдөд тараасан төсөл, илтгэл, танилцуулга, бусад материал. (Дүүрэг тус бүрт өөр буюу өөр нэртэй байж болно)		
Дүүргийн нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Засаг дарга “2015 онд хийсэн ажлын тайлан, 2016 онд хийх ажлын төлөвлөлт” гэсэн танилцуулга хийсэн.	
Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	2014 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцээгүй 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах танилцуулга хийснийг ИТХСүлжээний ажиглагчид файлаар өгсөн.	
Дүүргийн 2016 оны төсвийн төсөл, хавсралтууд, түүний танилцуулга буюу илтгэл	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид хуулбарлаж өгсөн	
Дүүргийн худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй	
Дүүргийн худалдан авах	Энэ тухай хэлэлцээгүй	

	ажиллагааны 2016 оны төлөвлөгөөний төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	
	Дүүргийн 2015 оны өмч хувьчлалын төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	1. Нээлттэй эх сурвалжид байхгүй 2. 2015 оны газар зохион байгуулалтын тайланг флашанд хуулж ИТХСүлжээний ажиглагчид өгсөн боловч алдаа заагаад нээгдэхгүй байгаа. 3. Газар зохион байгуулалтын 2015 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн баталсан тогтоолыг http://baganuur.ub.khural.mn/ сайтад байршуулсан байна.
	Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл, танилцуулга буюу илтгэл	1. Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг ИТХСүлжээний ажиглагчид өгсөн. 2. Нээлттэй эх сурвалжид байхгүй.
0	Хуралдааны ирцын бүртгэл	25 төлөөлөгч ирэхээс 23 нь оролцсон, 93 хувийн ирцтэй хуралдсан.
1	Бусад	Дүүргийн 35 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн санхүүгийн тайланг танилцуулсан.
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНААР БАТАЛСАН БОЛОН ДАРААХ БАРИМТ БИЧИГ (Хуралдаанаас хойш 7 хоногийн дотор)		
	Хуралдааны тэмдэглэл буюу протокол	1. ИТХСүлжээний ажиглагч аудио бичлэг хийсэн. 2. Албаны протоколыг ИТХСүлжээний ажиглагчид и-мэйлээр ирүүлсэн.
	Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтыг баталсан ИТХ-ын тогтоол, хавсралт	- http://baganuur.ub.khural.mn/ сайтад байршуулсан байна.
	Дүүргийн 2015 оны төсвийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны биелэлтийн явцыг дүгнэсэн ИТХ-ын тогтоол	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2016 оны батлагдсан төсөв (ИТХ-ын тогтоол, хавсралтын хамт)	- http://baganuur.ub.khural.mn/ сайтад байршуулсан байсан.
	Дүүргийн худалдан авах ажиллагааны 2016 оны батлагдсан төлөвлөгөө	Энэ тухай хэлэлцээгүй
	2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн батлагдсан жагсаалт	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн тогтоол	Нэг. Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт нээлттэй эх сурвалжид байхгүй байна.
	Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөө	Хоёр. Газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөө баталсан тогтоолыг www.khural.mn сайтад байршуулсан байсан.

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТОВЧОО
(ИТХ-ын хуралдааны үйл явц ба баримт бичиг)

Төсвийн үйл явц ба баримт бичиг		Иргэд, оршин суугч, сонгогчдод хэрхэн ил тод, нээлттэй байсан
ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ		
Дүүргийн 2016 оны төсвийн төлөвлөгөө		-
Дүүргийн 2016 оны төсвийн төсөл (Төсвийн тухай хуулиар, 2015.12.10-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлсэн)		- Нээлттэй эх сурвалжид байхгүй - “Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид өгөөгүй.
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНЫ ҮЙЛ ЯВЦ БА БАРИМТ БИЧИГ (2015.12.20-ны дотор хуралдсан)		
Дүүргийн ИТХ-ын хуралдааны үйл явцын ил тод, нээлттэй байдал		
	Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Иргэд төсвөө хянана сүлжээний ажиглагчид өгсөн байна.
Багахангай дүүргийн ИТХ-ын ээлжит 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудал 1. Дүүргийн ИТХ-аас 2015 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан 2. Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай 3. Дүүргийн Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн биелэлтийн явцын тухай 4. Дүүргийн 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт 5. Дүүргийн 2015 оны төсвийн тодотгол 6. Дүүргийн 2016 оны төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил батлах тухай 7. 2016 оны эдийн засаг, нийгмийн зорилтын тухай 8. Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай 9. Гэр хорооллын зарим гудамжийг хаягжуулж, нэршил олгох тухай 10. Бусад асуудал - Соёлын ордны авлага хүчингүй болгох тухай - Сурагчийн “Мини парламент”-аас гарсан саналыг дэмжих тухай - Дүүрэгт шаардлагатай боловсон хүчнийг түр орон байраар хангах тухай		
	Телевиз, радиогоор шууд дамжуулсан	Үгүй
	Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлчдийг оролцуулсан	-
	Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг ажиглагчаар оролцуулсан	“Иргэд төсвөө хянана” сүлжээний төлөөллийг ажиглалт хийлгэсэн.
Дүүргийн ИТХ-ын хуралдаанд өргөн барьсан, ИТХ-ын төлөөлөгчдөд тараасан төсөл, илтгэл, танилцуулга, бусад материал. (Дүүрэг тус бүрт өөр буюу өөр нэртэй байж болно)		
	Дүүргийн нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Дараах материалуудыг ажиглагчид өгсөн байна. 1. Нийслэлийн Багахангай дүүргийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын биелэлт тогтоолын төсөл, хавсралтуудын хамт 2. Дүүргийн Засаг даргын 2013-2016 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт
	Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	Дараах материалуудыг ажиглагчид өгсөн байна. 1. Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн батлах тухай тогтоолын төсөл
	Дүүргийн 2016 оны төсвийн төсөл, хавсралтууд, түүний	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид өгөөгүй.

	танилцуулга буюу илтгэл	
	Дүүргийн худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөний төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2015 оны өмч хувьчлалын төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид өгөөгүй.
	Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл, танилцуулга буюу илтгэл	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид өгөөгүй.
0	Хуралдааны ирцын бүртгэл	100 хувийн ирцийн бүртгэлтэй хуралдсан гэж хурлын тэмдэглэлд дурджээ
1	Бусад	
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНААР БАТАЛСАН БОЛОН ДАРААХ БАРИМТ БИЧИГ (Хуралдаанаас хойш 7 хоногийн дотор)		
	Хуралдааны тэмдэглэл буюу протокол	Дүүргийн хурлын ажлын албанаас албан бичиггүйгээр, амаар ярьсны дагуу ирүүлснийг tusuv.mn сайтад байршуулсан.
	Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтыг баталсан ИТХ-ын тогтоол, хавсралт	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид дараах материалыг гаргаж өгчээ. 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын биелэлтийн тухай ИТХ-ын тогтоол (хавсралтгүй) 2. Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилт батлах тухай ИТХ-ын тогтоол, хавсралтууд
	Дүүргийн 2015 оны төсвийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны биелэлтийн явцыг дүгнэсэн ИТХ-ын тогтоол	“Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид дараах материалыг гаргаж өгчээ. 1. Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай ИТХ-ын тогтоол, хавсралтууд 2. 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай ИТХ-ын тогтоол, хавсралтууд
	Дүүргийн 2016 оны батлагдсан төсөв (ИТХ-ын тогтоол, хавсралтын хамт)	Дүүргийн 2016 оны төсөв батлах тухай ИТХ-ын тогтоолыг хавсралтуудын хамт “Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид гаргаж өгчээ.
	Дүүргийн худалдан авах ажиллагааны 2016 оны батлагдсан төлөвлөгөө	Энэ тухай хэлэлцээгүй
	2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн батлагдсан жагсаалт	Энэ тухай хэлэлцээгүй
	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн тогтоол	Дүүргийн газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөг батлах тухай ИТХ-ын тогтоол, хавсралтуудын хамт “Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагчид гаргаж өгчээ.
	Дүүргийн 2016 оны газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөө	

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТОВЧОО
(ИТХ-ын хуралдааны үйл явц ба баримт бичиг)

Төсвийн үйл явц ба баримт бичиг		Иргэд, оршин суугч, сонгогчдод хэрхэн ил тод, нээлттэй байсан
ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ		
Дүүргийн 2016 оны төсвийн төлөвлөгөө		-
Дүүргийн 2016 оны төсвийн төсөл (Төсвийн тухай хуулиар, 2015.12.10-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлсэн)		Нээлттэй эх сурвалжид байхгүй байна.
ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНЫ ҮЙЛ ЯВЦ БА БАРИМТ БИЧИГ (2015.12.20-ны дотор хуралдсан)		
Дүүргийн ИТХ-ын хуралдааны үйл явцын ил тод, нээлттэй байдал		
Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	- Хуралдааны тов хэлэлцэх асуудлын жагсаалт нээлттэй эх сурвалжид байхгүй. - Хурлын нээлтэд хэлэлцэх асуудлын жагсаалтыг 6 гэж танилцуулсан тухай “Иргэд төсвөө хянана” сүлжээний ажиглагч хэлсэн.	
Баянгол дүүргийн ИТХ-ын ... хуралдаанаар хэлэлцсэн асуудал (хэлэлцэх асуудлын төлөвлөгөө албан ёсны байдлаар байхгүй байна) 1. Үйл ажиллагааны хөтөлбөр 2015 оны хэрэгжилт, 2016 оны зорилт 2. Газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөө 3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2015 оны биелэлт 4. 2014 оны төсвийн гүйцэтгэл 5. 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах (www.bgd.mn сайтад байгаа) 6. 2016 оны төсөв батлах тухай		
Телевиз, радиогоор шууд дамжуулсан	Үгүй	
Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлчдийг оролцуулсан	Хэвлэл мэдээллийн байгууллагаас сэтгүүлчид байгаагүй	
Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг ажиглагчаар оролцуулсан	“Иргэд төсвөө хянана” сүлжээний төлөөллийг ажиглалт хийлгэсэн.	
Дүүргийн ИТХ-ын хуралдаанд өргөн барьсан, ИТХ-ын төлөөлөгчдөд тараасан төсөл, илтгэл, танилцуулга, бусад материал. (Дүүрэг тус бүрт өөр буюу өөр нэртэй байж болно)		
Дүүргийн нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/	
Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/	
Дүүргийн 2016 оны төсвийн төсөл, хавсралтууд, түүний танилцуулга буюу илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/	
Дүүргийн худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/	
Дүүргийн худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөний	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn	

	төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	http://bayangol.ub.khural.mn/
	Дүүргийн 2015 оны өмч хувьчлалын төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга, илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/
	2016 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын төсөл, түүний танилцуулга буюу илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/
	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, илтгэл	Нээлттэй эх сурвалжид байхгүй байна. www.bgd.mn http://bayangol.ub.khural.mn/
